

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-8

---

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал 4-5

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 5-8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
06 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Т.Доржханд, Н.Учрал;  
Чөлөөтэй: Э.Болормаа, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, О.Номинчимэг, Ц.Туваан;  
Эмнэлгийн чөлөөтэй: О.Алтангэрэл, Л.Гантөмөр, Л.Энх-Амгалан.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

**Ц.Сандаг-Очир:** 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 10 гишүүнээс 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газраас 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 9 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

**Ц.Сандаг-Очир:** 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 4  
Бүгд: 14  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 9 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 16 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 9 цаг 57 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
9 цаг 41 минут.

### **ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Сандаг-Очир:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Дашзэвэгийн Амарбаясгалан, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Сандагийн Бямбацогт, Сархадын Зулпхар, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Одонгийн Цогтгэрэл, Өлзийхүүгийн Шижир нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. 2-т Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүний 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

#### **Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан ТББХ хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлдье, хуруугаа уншуулсан уу? Батын Батбаатар гишүүн чуулгандаа танхимдаа орж ирэхийг хүсэж байна. Баярмаа гишүүн, Бямбацогт гишүүн, Пүрэвдорж гишүүн, Уянгахишиг гишүүн, Цогтгэрэл гишүүдийг танхимдаа орж ирэхийг урьж байна. Санал хураалт эхлэх гэж байна. Гишүүд санал хураалт санал хураалтдаа бэлдээрэй. Дарга санал хураалтдаа бэлдлээ. Хуруугаа уншуулсан юм уу? Санал хураалтад бэлдээрэй.

Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа нарын 20 гишүүнээс 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69,2 хувиар санал дэмжигдлээ. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

9.47 цаг

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүнээс 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг хэлэлцэж эхэлъе. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа хийнэ. Булгантуяа даргын микрофоныг өгье.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төслийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяагаар ахлуулан 26 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Тус ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилт, мөн гадаад зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт, нийгмийн салбар, эдийн засаг, дэд бүтэц, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, орон тоотой холбоотой мэдээлэлтэй танилцаж санал, дүгнэлт гаргаж, өчигдөр Төсвийн байнгын хороон дээр танилцуулсан байгаа. Мөн бид Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

дараах санал, дүгнэлтүүдийг гаргаж, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлж байна.

1 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, энэ нөгөө дагалдах хууль руу нь орчихлоо. 1 дүгээрт, төсвийн төслийг жил бүр 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн барьж, 11 дүгээр сарын 15-нд батлахаар хуульчилсан байгаа. Гэхдээ Улсын Их Хурлын намрын чуулган 10 сард эхэлж, эхэлсэн даруйдаа төсвийн төслийг хэлэлцэж эхэлж байгаа нь төсвийн талаар Улсын Их Хурлын гишүүд, намын бүлэг, холбогдох талууд бүрэн танилцаж, олон нийтийн хэлэлцүүлэг хийж, үр дүнтэй ажиллах боломж хязгаарлалттай байгаа. Сая 9 сарын 1-нд өргөн барьсан ч гэсэн чуулган 10 сарын 1-ээс нааш эхлээгүй учраас 9 сарын хугацаанд бид олон төрлийн хэлэлцүүлэг, төсвийн мэдээллүүдийг төдийлөн сайн авч чадаагүй. Тийм учраас 9 дүгээр сарын 1-нээс, 9 дүгээр сарын 15-наас хаврын, намын чуулганыг Монгол Улсын Их Хурлын намрын чуулганыг эхлүүлж, төсвийн төслийг намын чуулган эхэлсэн өдрөөс эхлэн хэлэлцүүлэхээр төсвийн төсөлтэй танилцах хэлэлцүүлгийн шинэ үе шат нэмж, нийтдээ 5 үе шаттайгаар хэлэлцдэг байх нэмэлт, өөрчлөлт холбогдох хуульд орууллаа.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг зөвхөн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонсож, ердийн хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу Улсын Их Хурал хэлэлцэн баталж байгаа. Төсвийн байнгын хороо руу шилжүүлээд л, Төсвийн байнгын хорооноос буцаж нэгдсэн чуулган руу ордог гэсэн үг. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараа жилийн макро эдийн засаг, төсвийн үндсэн үзүүлэлтүүд, дунд хугацааны төсөөллийг тодорхойлох эдийн засаг, төсвийн бодлогын өндөр ач холбогдолтой баримт бичиг тул 4 үе шаттайгаар Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх тусгайлсан дэгийг бий болгож, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар сонсож, бүх Байнгын хороодоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хуралдаж, хамтарсан санал, дүгнэлт гаргах зохицуулалтыг бий болгож, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлтийг орууллаа.

Мөн Монгол Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг батлахдаа нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээгээр баталдаг. Мөн Засгийн газар Улсын Их Хуралд нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлангийн хамт өргөн мэдүүлээд улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоол баталдаг. Энэ нь Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлийг бүхэлд нь хянаж батлахгүй байгаа хууль буюу өөрөөр хэлбэл орон нутаг, нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан, Үндэсний баялгийн сангийн төсвийн гүйцэтгэлийг хянан батлахгүй байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл бид нэгдсэн төсвөө батлаад, улсын төсвийн гүйцэтгэлийг хэлэлцдэг гэсэн үг. Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зохих өөрчлөлтийг оруулж, баталсан хэм хэмжээгээрээ гүйцэтгэлийг сонсдог, баталдаг байхаар өөрчлөлт орууллаа.

Засгийн газраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, хөгжлийн төлөвлөгөөний төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг тодорхой хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлэх, Улсын Их Хуралд танилцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Ингэснээр төсвийн тогтвортой байдлын зөвлөл хуульд заасан дүгнэлт гаргаж, хяналт тавих Улсын Их Хуралд танилцуулах, гишүүдийг

мэдээллээр хангах, бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиудад холбогдох өөрчлөлтийг орууллаа, оруулахаар өргөн барилаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөвт тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбоотой төсөв хэлэлцэн батлах хугацаа чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг нэмэх шаардлагатай байна. Ингэснээр хоригийг хүлээн авснаас шалтгаалан төсвийг шинээр хэлэлцэх асуудал хууль зүйн маргаан үүсэхгүй байх, дэгийн хувьд эрх зүйн орчныг тодорхой болгосон байж байгаа. Дээрх санал дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, мөн холбогдох хуулиудад Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль зэрэг холбогдох хуулиудад өөрчлөлт оруулан өргөн барьж байна. Хэлэлцэн баталж өгнө үү.

**Ц.Сандаг-Очир:** Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Алга байна. Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримттай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн үзэл баримттай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж, үг хэлэх гишүүд байна уу? Сайнзориг гишүүн, Сайнзориг гишүүнээр тасаллаа.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Би хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Тэгээд 1 ийм асуудал байгаа. Би яах вэ нөгөө хууль зүйн салбарынхаа байгууллагуудын эрх ашгийг нэг бодолцож, энэ саналыг хэлж байгаа юм. Өнөөдөр Төрийн аудитын байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо зэрэг энэ байгууллагуудыг холбогдох Байнгын хороотой төсвөө урьдчилсан зөвшилцөөд, Сангийн яаманд хүргүүлдэг юм. Тэгэхээр энэ процедурыг энэ тодотголын үеэр яах ёстой байдаг вэ? Ер нь цаашдаа, магадгүй өнөөдөр улсын төсвийн тодотгол ч гэсэн энэ байгууллагуудтай яг энэ процедурыг гүйцээхгүйгээр л зардал мөнгийг нь хасаж байгаа тохиолдол гарах юм шиг байна.

Цаашдаа энэ ойлгомжгүй нөхцөл байдлууд чинь үл ойлголцол үүсэх эрсдэлтэй учраас тусад нь Үндсэн хуулиар заасан шүүх эрх мэдлийн байгууллагууд байгаад байгаа учраас, дээрээс нь эсвэл төрийн хяналт, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч гол Сангийн яамандаа хяналт тавьдаг, төсөв захирч байгаа хүмүүстээ хяналт тавьдаг Төрийн аудитын байгууллагын асуудал байгаад байгаа учраас магадгүй Булгантуяа гишүүний өргөн барьж байгаа энэ хууль маань нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнд байгаа байх. Ер нь энэ асуудлыг зарчмын хүрээнд анхаарч авч үзээч гэдэг зүйлийг л би зүгээр мэргэжлийн Байнгын хороонд орж ирж, хандаж хэлж байгаа юм. Баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтдаа бэлдлээ. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүнээс 9 гишүүн 69,2 хувиар дэмжлээ. Ахиад 2 санал хураалт байгаа шүү дагасан хууль.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол

Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 9 гишүүн дэмжиж, 69,2 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69,2 хувиар санал дэмжигдлээ.

4.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар санал дэмжигдлээ.

5.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 71,4 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна.

9.57 цаг

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА